



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2014 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 22

Мандалговь


Г

Хөрөнгө худалдах тухай

Г

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 2.1, 3.2.6.a дугаар заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Гурван сайхан сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй цахилгаан станцын барилга болон хүүхдийн цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй модон складыг тус тус актлан худалдахыг зөвшөөрсүгэй.
2. Цахилгаан станцын барилгын худалдах үнийн доод хязгаарыг 1'000'000 /нэг сая/ төгрөг, модон складны худалдах үнийн доод хязгаарыг 100'000 /нэг зуун мянга/ төгрөгөөр тус тус тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.
3. Худалдсан эд хөрөнгийг данс бүртгэлээс хасахыг Гурван сайхан сумын ЗДТГ-ын дарга Б.Энхтуяа, хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч С.Нарангэрэл нарт тус тус даалгасугай.



D:\Тогтоол-2014.docx

100000038